

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 05 сарын 10 өдөр

Дугаар: 08

Улаанбаатар хот

Д.Дуулалтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг  
цуцалж, дэд захирлын албан тушаалаас  
чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.9, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1.9, 80 дугаар зүйлийн 80.1.1, 83 дугаар зүйлийн 83.3, 83.4, Сангийн сайдын 2017 оны 01 дүгээр тушаалаар батлагдсан “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дүрмийн 4.2.3-т заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын Их Хурлаас 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр баталсан Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төрийн өмчийн оролцоотой нээлттэй компаниас бусад этгээд дэд захиралтай байхыг хориглосон тул Дамдиндоржийн Дуулалтай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцалж, 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөр тасалбар болгон “Үндэсний давхар даатгал” ХК-ийн дэд захирлын албан тушаалаас чөлөөлсүгэй.

2. Д.Дуулалын ажил хүлээлгэн өгөх хугацааг 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрөөр тогтоож, түүний ажлыг холбогдох хууль, журмын дагуу хүлээж авах, ажилласан хугацааны цалингийн болон бусад тооцоог хийж дуусгахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Жавхлант, Ерөнхий нягтлан бодогч Ч.Соронзонболд нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг Д.Дуулалд танилцуулж, хүлээлгэн өгөхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Б.Ангар)-д даалгасугай.

ДАРГА



З.ЭНХБОЛД